


МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЖЛЫН ТАЙЛАН



Тайлант хугацаа: 2025.01.01-2026.04.01

Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа	
1.	Компанийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах зэрэг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэх асуудлуудыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зохион байгуулж шийдвэрлүүлсэн. Компанийн засаглалын кодексийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлж 2026 оны 2 сарын хянан баталгаажуулсан байдлаар 59 оноо (84.17%)-ийн үнэлгээ авсан. Цаашид кодексийн зүйл заалтыг бүрэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
2.	ТУЗ өөрийн үнэлгээний аргачлал, загварыг боловсруулах, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах, ТУЗ болон хороод өөрийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулсан. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль, холбогдох бусад дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж-д тогтмол болон тухай бүр хүргүүлэх мэдээллийг хүргүүлж, компанийн засаглалын мэдээллийг компанийн вэб сайтад байршуулах, мэдээллийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.
3.	ТУЗ-ийн 2025 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр сард боловсруулан батлуулсан бөгөөд 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараа ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дараа оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хэрэгжихээр шинэчлэн боловсруулж, батлуулсан. ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангуулан, төлөвлөгөөг 100 хувь биелүүлж ажиллалаа.
5.	ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ТУЗ-ийн бүрэлдэхүүн орон нутгийн салбаруудын үйл ажиллагаа, FTTH төслийн хэрэгжилттэй танилцах дотоод томилолтын ажлыг зохион байгуулж, Орхон, Булган аймагт томилолтоор ажиллалаа.
Хувьцаа эзэмшигчдийн хурал	
6.	2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай шийдвэрийг гаргуулан, хурлын зарыг Хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлэх, компанийн сайтад байршуулах, олон нийтэд мэдэгдэх, хурлаар хэлэлцэх асуудлаар хурлын материалыг бэлтгэн, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх зэрэг зохион байгуулалтыг хангаж ажилласан. Хурал зохион байгуулахтай холбоотой ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний дагуу хурлыг 94.72 хувийн ирцтэйгээр 2025 оны 04 сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 6 асуудлыг хэлэлцүүлснээс хоёр асуудлыг танилцуулж, гурван асуудлыг баталж, нэг асуудлаар ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, сонгосон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас нийт 4 тогтоол батлагдан гарсан. 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ өөрийн үнэлгээний аргачлал, загварыг батлан гаргасан нь компанийн засаглалын сайн жишээ болсон гэж дүгнэж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын холбогдох 346 хуудас

	материалыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хуулийн хугацаанд хүргүүлэн тайлагнасан.
Төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын хурал	
7.	Тайлант хугацаанд ТУЗ-ийн 10, дэргэдэх хороодын 8, ажлын хэсгийн 2 хурлыг зохион байгуулж, ТУЗ-ийн хурлаар 27 асуудал хэлэлцүүлэн, 13 тогтоол, 4 тэмдэглэл гаргасан. ТУЗ болон дэргэдэх хороодын хурлыг гишүүдийн оролцоог хангахад анхаарч ажиллалаа. ТУЗ-ийн 8 хурлыг танхимаар, 2 хурлыг цахимаар хуралдуулж, ТУЗ-ийн хурлын ирц дунджаар 99 хувьтай байлаа. ТУЗ болон дэргэдэх хороодын хурлын бэлтгэл ханган материал боловсруулах, гаргуулах, хурлаар танилцуулах материалын агуулгыг хянах, шийдвэрийн төслийн бэлтгэх, мэдээлэл хүргэх ажлыг бүрэн биелүүлж ажилласан.
ТУЗ-ийн өөрийн үнэлгээ ба сургалт, семинар	
8.	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, дүгнэлт, тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын өөрийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг ТУЗ болон ХЭЭХ-аар танилцуулсан.
9.	ТУЗ-д шинээр сонгогдсон гишүүддээ танилцуулах сургалтыг зохион байгуулсан. ТУЗ-ийн гишүүдийг мэргэшүүлэх “Удирдагчийн сэтгэл зүй ба compassionate leadership” сэдвээр компанийн засаглалын ахисан түвшний сургалтад хамруулан гэрчилгээ олгосон. Сургалтыг Компанийн засаглалын хөгжийн төвтэй хамтран зохион байгуулж ТУЗ-ийн гишүүдийг бүрэн хамруулсан. Мөн БНСУ-д зохион байгуулагдсан “Дэлхийн төрийн өмчит компанийн хурал” уулзалтад нэг гишүүнээ хамруулсан.
Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт	
10.	"Компанийн засаглал"-ын кодексийн талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д танилцуулж ажилласан. Ногдол ашиг тараасан тайланг ХЭЭХ-аар танилцуулсан.
Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт	
11.	ТУЗ-өөр хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаар Гүйцэтгэх захирлын ажлын зөвлөлд танилцуулан, хэрэгжилтийг хангуулан ажилласан. ТУЗ-ийн хуралд хэлэлцсэн асуудал, шийдвэрлэсэн байдал, хэрэгжилтийн талаар тайлагнасан.
Компанийн бичиг баримтын бүрдэл, бүртгэл, хадгалалт	
12.	ТУЗ-ийн тогтоол, холбогдох материалыг цахим болон цаасан хэлбэрээр архивлан хадгалсан.

ХЯНАЖ, БАТАЛСАН:
ТУЗ-ИЙН ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х.ЦЭЦЭГМАА